

Дөрөв.Газрын үндсэн чиг үүрэг

4.1.Газар дараах үндсэн чиг үүргийг хэрэгжүүлнэ:

4.1.1.биеийн тамир, спортыг хөгжүүлэх талаар төрөөс баримталж байгаа бодлого, хууль тогтоомжийн хэрэгжилтийг нийслэлийн хэмжээнд зохион байгуулах;

4.1.2.нийслэлийн иргэдэд биеийн тамир, спортын үйлчилгээг чанартай, хүртээмжтэй хүргэх, биеийн тамир, спортыг хөгжүүлэх орчин, нөхцөлийг бүрдүүлэх;

4.1.3.нийслэлд биеийн тамир, спортыг хөгжүүлэх урт, дунд, богино хугацааны бодлого, хөтөлбөр, стратеги төлөвлөгөө боловсруулж, батлуулах, хэрэгжилтийг зохион байгуулах;

4.1.4.дүүрэг, хороо, хэсэг, төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж дэх биеийн тамирын хамтлаг, хамтлагийн арга зүйч, иргэдэд биеийн тамир, спортын ажлыг зохион байгуулах талаар мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгч, хамтран ажиллах;

4.1.5.биеийн тамир, спортын олон улсын уралдаан, тэмцээн, уулзалт, тоглолт, семинар, хурал, зөвлөгөөн, төрөл бүрийн сургалт, бусад арга хэмжээг Улаанбаатар хотод зохион байгуулахад мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлж, мэргэжлийн удирдлагаар хангах, энэ чиглэлээр холбогдох байгууллагуудтай хамтран ажиллах;

4.1.6.нийслэлд биеийн тамир, спортын уралдаан, тэмцээн зохион байгуулах, түрүүлсэн буюу шагналт байранд шалгарсан баг, тамирчид, дасгалжуулагчдад шагнал, шүүгчдэд урамшуулал олгох асуудлаар дүрэм, журам, заавар, хөтөлбөр, арга зүйн удирдамж, гарын авлага боловсруулан баталж мөрдүүлэх;

4.1.7.харьяа байгууллагуудын удирдах албан тушаалтнуудыг томилох болон зохион байгуулалтын бүтцийг боловсронгуй болгох асуудлаар санал, зөвлөмж, боловсруулж, эрх бүхий байгууллагаар шийдвэрлүүлэх;

4.1.8.биеийн тамир, спортын барилга байгууламжийг зориулалтаар нь ашиглахад анхаарч, тэдгээрийг түшиглэн биеийн тамир, спортын төвлөрсөн арга хэмжээг зохион байгуулах;

4.1.9.биеийн тамир, спортын ажил, үйлчилгээ, барилга байгууламж, заал, талбай, хэрэглэл, тоног төхөөрөмжийн чанар, стандарт боловсруулахад оролцох, хэрэгжилтэд нь хяналт тавих;

4.1.10.эрүүл аж төрөх ёс, зан үйл, биеийн тамир, спортын эрүүл мэндийн дэмжлэг үзүүлэх чиглэлээр олон нийтийг соён гэгээрүүлэх арга хэмжээ зохион байгуулах;

4.1.11.нийслэлийн иргэд, аж ахуйн нэгж, байгууллагуудын дунд биеийн тамир, спортын асуудлаар судалгаа явуулах, шаардлагатай мэдээ, мэдээллийг гаргуулан авах, нэгтгэх, дүн шинжилгээ хийх;

4.1.12.хариуцсан чиг үүргийн хүрээний асуудлаар ном, гарын авлага, зөвлөмж, эмхэтгэл, зурагт хуудас гаргах, сургалт явуулах.